



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 1/14

Мандалговь

Б.Шинэбаярыг Соёл, урлагийн газрын
Соёл, гэгээрлийн асуудал хариуцсан мэргэжилтний
албан тушаалд нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2023 оны 01 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


Нэг. Соёл, урлагийн газрын Соёл, гэгээрлийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Бүдбал овогтой Шинэбаяр 50.4 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Б.Шинэбаярын холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг Салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ТӨРБАТ





**Соёл, урлагийн газрын Соёл, гэгээрлийн асуудал
хариуцсан мэргэжилтний албан тушаалд
нэр дэвшүүлсэн Б.Шинэбаярын тухай дүгнэлт**

1. Б.Шинэбаяр нь 1974 онд Дундговь аймгийн Сайнцагаан суманд төрсөн. 49 настай, эмэгтэй
2. Боловсрол: 1992-1994 онд Соёлын коллежийг музейн ажилтан мэргэжлээр дипломын дээд, 2001-2003 онд Соёлын дээд сургуулийг соёлын менежмент мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн.
3. 1995-2003 онд аймгийн Музейд музейн тайлбарлагч, эрдэм шинжилгээний ажилтан, 2019-2021 онд БСУГ-т Соёлын өв хариуцсан мэргэжилтэн, 2021 оноос Музейн эрдэм шинжилгээний ажилтнаар тус тус ажиллаж байна.
4. Б.Шинэбаярын төрийн албаны дадлага туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Соёл урлагийн газрын Соёл, гэгээрлийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ